



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Тэрмэстий ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/248/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын Санхүүгийн аудитын хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:altantsetseg@audit.gov.mn">altantsetseg@audit.gov.mn</a> Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Голден пэйж Аудит ХХК Захирал: С.Оюунгэрэл Утас:70117179 Цахим хаяг: <a href="mailto:info@goldenpageaudit.mn">info@goldenpageaudit.mn</a>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соблын төв өргөө, Г хөрлос, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.15 № 618  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ТЭРМЭСТИЙ ӨЭМТ-ИЙН ДАРГА  
Ж.БОЛОРМАА ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Хан-Уул дүүргийн Тэрмэстий ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 51.7 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "үнэн зөв байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Тэрмэстий ӨЭМТ нь 4 төрлийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлд Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 978.6 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

### Аудитын гол асуудал

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.

1125050527

### **Бусад асуудлын хэсэг**

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Тэрмэстий ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/548 захирамжаар 96.7 хувь, Дүүргийн эрүүл мэндийн төвөөс эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах гэрээний биелэлтийг 96 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	11,930,383.83	12,943,847.43
Бусад авлага	81,095,974.99	9,814,076.30
Бараа материал	23,672,931.50	23,002,885.00
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>116,699,290.32</b>	<b>45,760,808.73</b>
Үндсэн хөрөнгө	355,180,784.04	346,162,282.76
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>355,180,784.04</b>	<b>346,162,282.76</b>
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>471,880,074.36</b>	<b>391,923,091.49</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>		
<b>Өр төлбөр</b>		
Дансны өглөг		
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	-
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	-	-
<b>Өмч</b>	<b>21,713,707.64</b>	<b>21,713,707.64</b>
Төрийн	21,713,707.64	21,713,707.64
Хувийн		-
Хуримтлагдсан ашиг	450,166,366.72	370,209,383.85
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>471,880,074.36</b>	<b>391,923,091.49</b>
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>	<b>471,880,074.36</b>	<b>391,923,091.49</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>Борлуулалтын орлого</b>	<b>971,427,271.79</b>	<b>5,678,700.00</b>
<b>Нийт ашиг</b>	<b>971,427,271.79</b>	<b>5,678,700.00</b>
<b>Түрээсийн орлого (Санхүүжилтийн орлого)</b>		<b>908,502,429.50</b>
<b>Хүүний орлого</b>	<b>301,115.41</b>	<b>242,051.50</b>
<b>Бусад орлого (үнэгүй орлого, бусад)</b>	<b>277,501,325.00</b>	<b>38,714,953.27</b>
Ерөнхий удирдлагын зардал	944,022,681.07	1,033,095,117.14
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>305,207,031.13</b>	<b>(79,956,982.87)</b>
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>305,207,031.13</b>	<b>(79,956,982.87)</b>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>305,207,031.13</b>	<b>(79,956,982.87)</b>
<b>Бусад олз/ гарз</b>		-
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>305,207,031.13</b>	<b>(79,956,982.87)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>930,181,672.21</b>	<b>990,404,488.96</b>
Татаас санхүүжилтийн орлого	681,892,131.80	984,725,788.96
Бусад мөнгөн орлого	248,289,540.41	5,678,700.00
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>908,580,543.21</b>	<b>969,079,076.86</b>
Ажиллагчдад төлсөн	535,061,934.00	697,345,061.77
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	112,820,674.91	80,935,343.66
Бараа материал худалдан авахад төлсөн	166,662,147.00	112,345,821.40
Ашиглалтын зардалд төлсөн		1,914,168.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		2,904,400.00
Татварын байгууллагад төлсөн	54,363,015.00	655,608.00
Даатгалын байгууллагад төлсөн		109,920.00
Бусад мөнгөн зарлага	39,672,772.30	72,868,754.03
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>21,601,129.00</b>	<b>21,325,412.10</b>
<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>-</b>	<b>242,051.50</b>
Хүлээн авсан хүүгийн орлого		242,051.50
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>11,573,905.00</b>	<b>20,554,000.00</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	11,573,905.00	20,554,000.00
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(11,573,905.00)</b>	<b>(20,311,948.50)</b>
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>10,027,224.00</b>	<b>1,013,463.60</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,903,159.83</b>	<b>11,930,383.83</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>11,930,383.83</b>	<b>12,943,847.43</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>21,713,707.64</b>	<b>144,959,335.59</b>	<b>166,673,043.23</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-
Залруулсан үлдэгдэл	21,713,707.64	144,959,335.59	166,673,043.23
Тайлант үеийн ашиг		305,207,031.13	305,207,031.13
Өмчид гарсан өөрчлөлт			-
<b>2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>21,713,707.64</b>	<b>450,166,366.72</b>	<b>471,880,074.36</b>
Тайлант үеийн ашиг		(79,956,982.87)	(79,956,982.87)
<b>2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>21,713,707.64</b>	<b>370,209,383.85</b>	<b>391,923,091.49</b>

**Гурав. Аудитын илрүүлэлт:** Аудитаар нийт 51,729.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 20,241.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 18,000.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 13,487.5 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин илүү тооцоолж олгосон	1	20,241.6	1	20,241.6				
Нэг удаагийн тэтгэмж олгосон	1	18,000.0			1	18,000.0		
Анхан шатны баримтын бүрдэлт дутуу гүйлгээ хийсэн байна	1	11,201.5					1	11,201.5
Хөрөнгийн бүртгэлд үнэ цэнэгүй, үлдэх ертөггүй болсон хөрөнгө ашиглагдаж байна.	1						1	
Орлогыг дутуу бүртгэсэн байна.	1	2,286.0					1	2,286.0
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>51,729.1</b>	<b>1</b>	<b>20,241.6</b>	<b>1</b>	<b>18,000.0</b>	<b>3</b>	<b>13,487.5</b>

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд гүйлгээг дутуу мэдээлсэн байна.	1	80,802.9					1	80,802.9
Дүн	1	80,802.9					1	80,802.9
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг төлөвлөөгүй хөрөнгө худалдан авсан	1	131,027.2					1	131,027.2
Бараа материалын дансанд үнэ төлбөргүй ирсэн орлогыг аваагүй байна.	1	359.4					1	359.4
Байр ашиглалт, урсгал засвар, түрээсийн зардал эрүүл мэндийн санхүүжилтийн орлогоос зарцуулсан байна.	1	9,751.0					1	9,751.0
Дүн	3	141,137.6					3	141,137.6
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>221,940.5</b>					<b>4</b>	<b>221,940.5</b>

